



МОНГОЛ УР ЧАДВАР-2023

Мэргэжлийн боловсрол сургалтын салбарын суралцагчдын ур чадварыг олон улсын түвшинд хүргэх сургалтын чанарыг дээшлүүлэх, бэлтгэн гаргаж буй мэргэжилтний үнэлэмжийг өсгөх, мэргэжлийн бахархлыг бий болгох зорилго бүхий Монгол ур чадвар тэмцээнийг БШУЯ, Мэргэжлийн Боловсрол сургалт түншлэл ТББ, Мэргэжлийн Холбоод 2013 оноос хойш жил бүр тогтмол зохион байгуулж байгаа билээ

Монгол ур чадвар 2023 тэмцээн 8 мэргэжлээр 3 үе шаттайгаар Мужаан, Сантехник, Цахилгаан График дизайн, Гагнуур, CNC Токарь Өрөг угсрагч Тогооч нийт 8 мэргэжлээр зохион байгуулагдаж өнөөдөр ялагчаа тодрууллаа

Тэмцээний эхний шат 2023 оны 05 дугаар сарын 29-31ний өдрүүдэд зохион байгуулагдаж тэмцээнд нийт 138 суралцагч хурд, хүч, авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдсөн юм.

Тэмцээний хоёрдугаар шат 10 сарын 2-3 ны өдрүүдэд болж МТБСБ-ын 41 суралцагчид шалгарч гуравдугаар шатанд өрсөлдөх эрхээ авсан билээ.

Сүүлийн шатны тэмцээн 12 сарын 13-15ний өдрүүдэд зохион байгуулагдаж үндэсний ялагчаа тодрууллаа.

Монгол ур чадвар тэмцээний Тогооч" мэргэжлийн төрөлд манай сургуулийн Тогооч ангийн суралцагч Ц.Тэмүүлэн Тэргүүн байр эзэллээ

Шилдгээр шалгарсан Ц.Тэмүүлэн маань Бүгд Найрамдах Франц Улсад 2024 оны 9 дүгээр сард болох Дэлхийн ур чадварын 47 дах тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцох юм



УР ЧАДВАРЫН УРАЛДААН

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь 2023-2024 оны хичээлийн жилд Pearson BTEC олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд суралцаж буй нийт оюутан суралцагчдын дунд 4 чадамжийн нэгжийн хүрээнд ур чадварын уралдааныг зохион байгууллаа





НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь БНСУ-ын Кён Ин эмэгтэйчүүдийн их сургуультай хамтарсан 1+1 хөтөлбөрөөр Агаарын хөлгийн үйлчилгээний ажилтан мэргэжлээр 6 дах элсэлтээ Зочид буудал зоогийн газрын үйлчилгээний ажилтан мэргэжлээр эхний элсэлтээ авч амжилттай хэрэгжүүлж байна

Цаашид Гоо засалч мэргэжлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан. Манай хоёр сургууль жил бүр хамтын ажиллагаагаа өргөжүүлж өвөл зуны оюутан солилцооны хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлдэг билээ Кён Ин эмэгтэйчүүдийн их сургуулийн 20 оюутан багшийн хамт солилцооны хөтөлбөр, туршлага солилцох үйл ажиллагааны хүрээнд манай сургууль дээр 2023.12.18-22 өдрүүдэд 4төрлийн сургалтыг зохион байгууллаа



СПОРТЫН ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО.

Барилгын политехник коллежийн нэрэмжит Улаанбаатар бүсийн МБТБСБ-ын суралцагчдын дунд зохиогдсон "САГСАН БӨМБӨГ"-ийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчид маань амжилттай оролцож ДЭД байр эзэллээ Мөн ЦХЗ2а ангийн суралцагч М.Гантөгс тэмцээний "БЭЛЭГДЛИЙН ГАРААНЫ 5-Н ТОГЛОГЧ" боллоо



УРИЛГА ДЭВШҮҮЛЛЭЭ.

Pearson BTEC хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутан суралцагчдад Universal- Z номын клубын чиглүүлэгч багш Ч.Нямсүрэн клубын талаарх мэдээ мэдээллийг танилцуулан ном унших уриалгыг дэвшүүллээ



976+11350209

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

www.pas.mn



НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

10 САЯ ТӨГРӨГНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЛЭЭ

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын эрх зүйн орчин сайжруулах, сургалтын стандарт, сургалтын орчин материаллаг баазыг хөгжүүлэх, суралцагчдыг үйлдвэр аж ахуйн нэгж дээр дадлагажуулж ажлын байран дах ур чадварыг сайжруулах мэргэжлийн багш нарын ур чадварыг дээшлүүлэхэд ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэх харилцан туршлага судлах зэрэг зорилтуудын хүрээнд Сувдан тамир elektrik ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулаад 3 дах жилдээ амжилттай хамтран ажиллаж байна

Сувдан тамир elektrik ХХК нийгмийн түншлэлийн үйл ажиллагааны хүрээнд ЦАХИЛГААНЫ мэргэжлийн ангийг тохижуулахаар 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ



"МЯНГАН ЦЭЦЭГСИЙН ЧУУЛГАН"

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн хамтран ажиллах ажлын хүрээнд зохион байгуулсан "Мянган цэцэгсийн чуулган"-ыг сургуулийн 320 охидын дунд зохион байгуулсан нь салбартаа анхдагч үйл ажиллагаа боллоо

Энэхүү үйл ажиллагааг ҮУПК-ийн сургалтын албаны менежер Б.Мядагбадам нээж МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ж.Нямаа Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн хөгжил хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн Б.Болор-Эрдэнэ, МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн Э.Бүжин нар "Нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Гэр бүл төлөвлөлт", "Өсвөр үе ба Ирээдүй", "Үе тэнгийнхний дээрэлхэлт" сэдвээр илтгэл тавьж оролцлоо. Мөн чуулганы хүрээнд ҮУПК-ийн "Нарны охид" клуб албан ёсоор зохион байгуулагдаж нээлтээ хийлээ



☎ 976+11350209

f Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

🌐 www.pas.mn

СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2023 оны 12 сарын 01-ны өдөр ҮУПК дээр суралцагчдын зөвлөлүүдийг чиглүүлэгч багш нар, "Нарны охид" охидын зөвлөл, "Boys' council" хөвгүүдийн зөвлөл болон оюутны зөвлөлийн гишүүд Монгол Солонгосын Политехник Коллежийн англи хэлний багш Д. Тайванжаргал, "Wonder" клуб болон оюутны зөвлөлийн гишүүдийг хүлээн авч танилцах уулзалт зохион байгууллаа.

Уулзалтын үеэр 2 сургуулийн суралцагчид харилцан туршлага солилцож цаашид хамтран ажиллах, мөн МБС-ын байгууллагын оюутан суралцагчдын дунд ХГҮА - ны чиглэлээр суралцагчдыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, суралцагчдын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулан хамтарч ажиллахаар боллоо



СУРГАЛТ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн "Үсчин" мэргэжлээр сурч байгаа суралцагчдад EKOSS HAIR салоны захирал Д.Отгонжаргал Tahe брэндийн үс хуй арчилгааны сургалтыг зохион байгууллаа



“ХАЛДВАРГҮЙ ИРЭЭДҮЙД ХАМТДАА” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА


ДОХ тэмцэх дэлхийн өдөр 12 сарын 01 өдөр Байгалийн Ухааны Тэнхимээс “Халдваргүй ирээдүйд хамтдаа” гар зургийн уралдааныг сургуулийн урлагийн мэргэжлийн ангиудын дунд зарлаж Тэргүүн байрыг ҮЭД1а ангийн Тэргэл ахлагчтай багдэд байрыг ЗЧ2а ангийн Анунгоо ахлагчтай баг эзэллээ

Мөн тус өдөр сургуулийн спорт зааланд 300 суралцагчдад СБД-ийн Улаан Загалмайн Хорооны дарга Б.Мөнхбаяр ДОХ өвчний тархалт сэргийлэх арга” зам сэдэвт сургалтыг сургуулийн Улаан Загалмайн багтай хамтран хийлээ



ЦАХИМ УРИАЛГА ДЭВШҮҮЛЛЭЭ.

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн оюутан суралцагчид УХААЛАГ УТАСНЫ ЗӨВ ХЭРЭГЛЭЭГ ХЭВШҮҮЛЬЕ” цахим уриалгыг дэвшүүллээ.



📞 976+11350209

📍 Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

🌐 www.pas.mn

СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

2023 оны 12 сарын 07 өдөр Байгалийн Ухааны Тэнхимийн ёс зүйн сарын аяны хүрээнд Нийгмийн Ухааны багш Б.Урантогосын хамт комедиан Д.Амартүвшинг урьж суралцагчидтай Сонгодог либерал үзэл, хүний эрх, эрх чөлөөний тухай ярилцлаа



ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2023.12.13 ны өдөр YУПК-ийн 1-р курсийн суралцагчдын дунд Монголын түүх, 2-р курсын суралцагчдын дунд Нийгэм судлалын хичээлийн олимпиад амжилттай болж өндөрлөлөө

PRODUCTION
АТ

Монголын түүхийн хичээлийн олимпиадын дүн

I байрт: ӨСО 16 ангийн суралцагч Э.Адьяасүрэн

II байрт: ӨСО15 ангийн суралцагч Ш.Номиносинг

III байрт: ӨСО1а ангийн суралцагч М.Базаргүрэм

Тусгай байрт: Гoo16 ангийн суралцагч М.Хадармаа

Нийгэм судлал хичээлийн олимпиадын дүн

I байрт: Нбдхаха2а ангийн суралцагч О.Ариун-Эрдэнэ

II байрт: Эбабуа 2а ангийн суралцагч Ч.Оюун-Эрдэнэ

Амх2а ангийн суралцагч Т.Балсансэмбэрэл

III байрт: Гoo2а ангийн суралцагч Э.Номи-Эрдэнэ,

Эбхүба2а ангийн суралцагч Х.Саруул

Хүмүүнлэгийн ухааны тэнхим



ДЭВЖЭЭ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Хүмүүнлэгийн Ухааны тэнхимийн Нийгмийн ухааны хөтөлбөрийн багаас "Дэвжээ" тэмцээнийг зохион явууллаа

"Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр"-ийг тэмдэглэхийн ач холбогдол, тусгаар тогтнолын үнэ цэнийг хойч үедээ мэдүүлэх YУПК – багш оюутан суралцагчдад сурталчлан таниулах, суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор 7 тэнхимийн суралцагчдын дунд дэвжээ тэмцээнийг зохион байгууллаа

Тэмцээний шалгуур:

1. Багуудын мэндчилгээ
 2. Багуудын дунд асуулт хариултын тэмцээн
 3. Багуудад өгсөн гэрийн даалгавар-
 4. Багийн ахлагч нарын дундах асуулт хариултын тэмцээн гэсэн 4 төрлөөр явагдсан ба тэмцээний шүүгчээр Монголын түүх, ёс зан, заншлын багш С.Мөнхсайхан Амьдрах ухаан, хүний хөгжлийн хичээлийн багш Д.Болор-Эрдэнэ Солонгос хэлний багш Э.Цэдэнсодном нар шүүлээ
- Тэмцээнд нийт 7 тэнхимийн багш нар, 7 багийн 56 суралцагч оюун билэг, авхаалж самбаагаа сорьж идэвхийлэн оролцсоноос багийн дүнгээр Yйлдвэрлэлийн тэнхим 1-р байр- өргөмжлөл мөнгөн шагнал Техник технологийн тэнхим 2-р байр- өргөмжлөл мөнгөн шагнал Хүмүүнлэгийн ухааны тэнхим 3-р байр – өргөмжлөл мөнгөн шагналыг тус тус хүртлээ

